



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Сүхбаатар аймаг дахь төрийн
аудитын газар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ ТӨСӨВЛӨЛТИЙН
ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛЖ БАЙГАА НЬ
ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧАНАР, ҮР ДҮНД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БАЙНА.

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023 ОНЫ
БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД: СБА-2024/26-15-ШТА-ГА

Баруун-Урт 2024 он



Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Н.Болдбаатар

Утас: 70512127 Цахим хаяг: boldbaatarn@audit.gov.mn

Аудитор Э.Алтансүх

Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Аудитор Б.Ганцэцэг

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл4
БҮЛЭГ А. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ БАТЛАХ ЗӨРЧЛИЙГ ДАВТАН ГАРГАСААР БАЙНА. 5

1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна. 5

1.1.1. ОНХНС-ийн эх үүсвэр бүрдүүлэлтийг Сангийн яам төлөвлөж байна. 5

1.1.2. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль, журмыг баримтлан, хуваарилж олгосон байна. 5

1.1.3. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна. 5

1.1.4. Аймаг, сумын ОНХС-д хуульд заасан эх үүсвэрийг судалж, орон нутгийн хөгжлийн санд 16.1 тэрбум төгрөг нэмж төлөвлөжээ. 5

1.2. Сумдын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэдийн саналгүй төлөвлөсөөр байна. 6

1.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдийн саналгүй 30 төсөл арга хэмжээ батлагдсан байна. 6

1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад дахь 424 төсөл арга хэмжээнээс 2 төсөл арга хэмжээ нь ажлын байр бий болгоход чиглэсэн байна. 6

1.2.3. Ажил гүйцэтгэх төсөл арга хэмжээг магадлалын дүгнэлтгүй, тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээг мэргэжлийн байгууллагын зах зээлийн үнэлгээгүй төлөвлөх зөрчил давтагдсан байна. 7

1.2.4. Батлагдсан нийт төсөл арга хэмжээний 25 хувийг орчны тохижилттой холбоотой төсөл арга хэмжээ эзэлж байна. 8

БҮЛЭГ Б. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН 4 АРГА ХЭМЖЭЭ ТУТМЫН 1 НЬ ОГТ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.9

2.1. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжийг баримтлаагүй зөрчлүүд гарсаар байна. ... 9

2.1.1. Магадлалын дүгнэлтгүй зураг төслөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулах, батлагдсан төсөвт өртгөөс илүү дүнгээр гэрээ байгуулах зөрчлүүд давтагдаж байна. 9

2.1.2. Банкны баталгаагүйгээр урьдчилгаа олгох, бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгох зөрчил гарсаар байна. 10

2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 4 арга хэмжээ тутмын 1 нь огт хэрэгжээгүй байна. 12

2.2.1. Магадлалын дүгнэлтгүй төсөл арга хэмжээг баталж байгаа нь тухайн төсөл арга хэмжээ хэрэгжихгүй байх, хугацаа алдахад нөлөөлж байна. 12

2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнээс 14,325.2 төгрөгийн төсөвт өртөгтэй 101 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. 12

2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна. 13

2.3.1. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна. 13

2.3.2. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зохистой байна. 13

БҮЛЭГ В. ШАТ ШАТНЫ ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХИЙН ТУЛД ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛЖ, СУРГАЛТ ХИЙХ ШААРДЛАГА ҮҮССЭН БАЙНА.	13
3.1. Магадлалын дүгнэлтгүй төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж байгаа нь шат шатны хяналтыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.	13
3.1.1. Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, дотоод аудит нь ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд хяналтыг хэрэгжүүлсэн байна.	13
3.1.2. Магадлалын дүгнэлтгүй төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж байгаа нь барилгын техник хяналт хэрэгжихгүй байхад шууд нөлөөлж байна.	14
3.1.3. Өмнөх аудитаар хүргүүлсэн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.	15
3.2. Удирдлагын мэдээллийн систем болон шилэн дансанд сумдын байршуулж буй ОНХС-ийн мэдээлэлд АЗДТГ-аас хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.	16
3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг холбогдох журам, зааврын дагуу хугацаанд нь тайлагнасан байна.	16
3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээний 97.8 хувийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.	16
3.2.4. Шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээлж буй орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлд АЗДТГ-ын ОНХС хариуцсан албан хаагч	17
Холбогдох байгууллагын санал:	18
Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:	19
ДҮГНЭЛТ:	19
ЗӨВЛӨМЖ:	19

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
АИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УИХ	Улсын Их хурал
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл		
Аудит үндэслэл, эрх	хийх бүрэн	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолыг үндэслэн гүйцэтгэв.
Аудитын зорилт		“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.
Аудитын хүрээ	хамарсан	Аудитад ОНХС-ийн 2023 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, төсөл, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайлан, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд Сүхбаатар аймгийн Засаг дарга, харьяа байгууллагууд, аймгийн Засаг даргын тамгын газар, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Сүхбаатар хот байгуулалт, орон сууц, барилга захиалагчийн алба болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт		Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа авах арга зүйг ашиглаж аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа		Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Болдбаатар, аудитор Э.Алтансүх, Б.Ганцэцэг нар 2024 оны 05 сарын 20-ны өдрөөс 7 сарын 05-ний өдрийг хүртэлх хугацаанд аудитыг гүйцэтгэв.

БҮЛЭГ А. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ БАТЛАХ ЗӨРЧЛИЙГ ДАВТАН ГАРГАСААР БАЙНА.

1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.

1.1.1. ОНХНС-ийн эх үүсвэр бүрдүүлэлтийг Сангийн яам төлөвлөж байна.

1.1.1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэр бүрдүүлэлт нь Сангийн яамны эрх, үүрэгт хамаарах бөгөөд аймаг, орон нутгийн чиг үүрэгт хамааралгүй байна.

1.1.2. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль, журмыг баримтлан, хуваарилж олгосон байна.

1.1.2.1. ОНХНС-аас Сүхбаатар аймгийн орон нутгийн хөгжлийн санд 17,153.8 сая төгрөгийг хууль, журмын дагуу олгосон байна. Аймагт 2023 онд олгосон шилжүүлгийг эх үүсвэрээр ангилж, хүснэгтээр харуулбал:

		/сая.төг/
№	Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр	Мөнгөн дүн
1	Газрын тосны нөөц ашигласны төлбөр	523.3
2	АМНАТ	15,245.8
3	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл	193.1
4	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл	385.0
5	ОУ-ын байгууллагын төслөөс олгож буй урамшуулал	806.6
Нийт дүн		17,153.8

1.1.3. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.

1.1.3.1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох 8,898.7 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна. Сумдын ОНХС-д 2023 онд олгосон орлогын шилжүүлгийг хүснэгтээр харуулбал:

			/сая.төг/		
№	Сумын нэр	Орлогын шилжүүлэг	№	Сумын нэр	Орлогын шилжүүлэг
1	Асгат	409.8	8	Сүхбаатар сум	700.8
2	Баруун-Урт	1,324.6	9	Түвшинширээ	569.4
3	Баяндэлгэр	760.5	10	Түмэнцогт	339.9
4	Дарьганга	598.3	11	Уулбаян	461.3
5	Мөнххаан	808.2	12	Халзан	325.4
6	Наран	408.4	13	Эрдэнэцагаан	1,536.2
7	Онгон	655.9			
		Дүн			8,898.7

1.1.4. Аймаг, сумын ОНХС-д хуульд заасан эх үүсвэрийг судалж, орон нутгийн хөгжлийн санд 16.1 тэрбум төгрөг нэмж төлөвлөжээ.

1.1.4.1. Аймгийн хэмжээнд орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэрийг 2023 онд 16.1 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн, гүйцэтгэлээр 2.2 тэрбум төгрөгийн орлогын гүйцэтгэлтэй байна. Үүнээс малын тоо толгойн албан татварын орлогын гүйцэтгэл 783.9 сая төгрөг байна.

1.2. Сумдын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэдийн саналгүй төлөвлөсөөр байна..

1.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдийн саналгүй 30 төсөл арга хэмжээ батлагдсан байна.

1.2.1.1. Аймгийн ОНХС-ийн хувьд 2023 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг Google forum-аар авсан байна. Харин сумдын ОНХС-ийн хувьд 30 төсөл арга хэмжээ иргэдийн саналгүй байна. Энэ нь “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.7.5¹ дахь заалтыг зөрчсөн байна.

1.2.1.2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ” гэж заасны дагуу иргэдийн санал авсан төсөл арга хэмжээг санхүүжүүлэх шаардлагатай байна. Иргэдийн саналыг Орон нутгийн хөгжлийн сангийн Удирдлагын мэдээллийн системээр дамжуулан авч хэвшихэд шаардлагатай гарын авлага, мэдээллийг боловсруулж, сургалт зохион байгуулах арга хэмжээг Төрийн аудитын байгууллагын зүгээс аймаг, сумын ЗДТГ-ын албан хаагч нартай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

1.2.1.3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдэд санал авах гар утасны аппликейшний талаарх сургалт, сурталчилгааны ажлууд хийх зайлшгүй шаардлага үүссэн байна. Энэ шаардлагын дагуу Тогтвортой амьжиргаа-3 төслөөс “ОНХС” гар утасны аппликейшнийг ашиглаж иргэдээс туршилтаар санал авах чиглэлийг аймгийн Засаг даргад албан бичгээр хүргүүлсэн бөгөөд аппликейшний холбогдолтой контент, хэвлэмэл материалын эх, хэвлэлийн бага хурлын мэдээ, нийгмийн сүлжээний хуудаснуудын идэвхжүүлэх материалуудыг ОНХС-ийн www.tusuv.oronnutag.mof.gov.mn цахим хуудасны ОНХС-ийн “Хэвлэмэл материал, контентууд” дэд цэсийн 21 дугаарт татаж авах боломжтойгоор байршуулсан байна.

1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт дахь 424 төсөл арга хэмжээнээс 2 төсөл арга хэмжээ нь ажлын байр бий болгоход чиглэсэн байна.

1.2.2.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хувьд орон нутгийн иргэдийг авч ажиллуулж түр ажлын байр бий болгож байгаа боловч байнгын ажлын байр бий болгоход чиглэсэн төсөл арга хэмжээ батлагдахгүй байна. Орон нутгийн хөгжлийн сангийн журмын хүрээнд тухайн сангийн хөрөнгөөр ажлын байр бий болгох чиглэсэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх

¹ 4.7. Энэ зүйлийн 4.6-д зааснаар ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах зөвшөөрөхгүй зардалд дараах хамаарах ба үүгээр хязгаарлагдахгүй: 4.7.5. Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ;

боломжтой бөгөөд Сүхбаатар аймгийн хэмжээнд 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр ажлын байр бий болгоход чиглэсэн 2 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.2.2.2. Харин Асгат сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 575.0 сая төгрөгийн төсөвтэй 1 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна. Тодруулбал “Нийтийн ахуйн үйлчилгээний барилга” төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг 2024 оны 5 сард тодруулсан байна. Тус төсөл арга хэмжээний хүрээнд баригдах ахуйн үйлчилгээний барилгад гуталчин, үсчин, цайны газар гэх мэт үйл ажиллагаа явуулах 8 өрөө тасалгаатай байх бөгөөд ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байна. Цаашид сумд ажлын байр бий болгоход чиглэсэн төсөл арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.2.3. Ажил гүйцэтгэх төсөл арга хэмжээг магадлалын дүгнэлтгүй, тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээг мэргэжлийн байгууллагын зах зээлийн үнэлгээгүй төлөвлөх зөрчил давтагдсан байна.

1.2.3.1. Машин, тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээний төсөвт өртгийг тодорхойлохдоо мэргэжлийн байгууллагын дүгнэлт, тайланд үндэслэх шаардлагатай байна. Тодруулбал тоног төхөөрөмжийн зах зээлийн үнийн судалгааг мэргэжлийн буюу хөрөнгийн үнэлгээний компаниудаар хийлгэснээр Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангах буюу үндэслэлтэй төлөвлөлт хийгдэх боломж нөхцөл бүрдэхээр байна. Мөн тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээний төсөвт өртгийг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулснаар дараах 2 төрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой болно. Үүнд:

- *Зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авалт хийх болон авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдох эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.*
- *Төсөвт өртөг тогтоолд бага дүнгээр батлагдсанаас болж тендерт нэг ч оролцогч санал ирүүлэхгүй байх, удаа дараа зарлаж, цаг хугацаа алдах эрсдэлийг бууруулна.*

1.2.3.2. Барилгын ажил гүйцэтгэх төсөл арга хэмжээний зураг төсөл нь Барилгын хөгжлийн төвөөр хянагдаагүй, магадлалын ерөнхий дүгнэлт гараагүй байхад аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдаж байгаа зөрчил давтан гарсаар байна.

1.2.3.2. Тухайлбал Асгат, Баяндэлгэр, Дарьганга, Мөнххаан, Онгон, Түвшинширээ, Эрдэнэцагаан сумд 1,795.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл арга хэмжээг магадлалаар баталгаажсан зураг төсөлгүйгээр төсөвт тусгаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгүүлжээ.

1.2.3.3. Төсөл арга хэмжээг магадлалгүй төлөвлөсний улмаас худалдан авах ажиллагаа зарлагдахгүй удаашрах, баталгаажаагүй зураг төслөөр тендер зарлан гүйцэтгэгч тодруулж, захиалагчийн барилгын техник хяналтгүйгээр барилгын ажил хэрэгжиж байна. Энэ нь барилгын чанарт шууд сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд төсвийн хөрөнгийн үргүй зарцуулах эрсдэлд хүргэсэн байна.

1.2.3.4. Аймаг, сумын ИТХ нь Төсвийн тухай хуульд нийцээгүй төсөл, арга хэмжээг баталж байгаа зөрчлийг арилгах зөвлөмжийг жил бүр төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудит болон бусад аудитаар өгдөг боловч энэхүү зөрчил бүрэн арилахгүй байна. Иймд цаашид аймаг, сумын төсөвт магадлалгүй төсөл арга хэмжээ батлагдсан тохиолдолд тухайн зөрчлийг арилгуулахын тулд Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу шүүх, прокурорын байгууллагын туслалцаатайгаар аудитын шийдвэрийг албадан хэрэгжүүлэх шаардлага үүсэж байна.

1.2.4. Батлагдсан нийт төсөл арга хэмжээний 25 хувийг орчны тохижилттой холбоотой төсөл арга хэмжээ эзэлж байна.

1.2.4.1. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний чиг үүргийг ОНХС-ийн журамд дараах байдлаар зааж өгсөн. Үүнд: Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэн ухаан, цахим технологи, дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ, орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах, ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулах, хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулах, бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх, **өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт, ажлын байр бий болгох** чиг үүргийн хүрээнд төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна.

1.2.4.2. Мөн сумдын ОНХС-ийн малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээр бэлчээрийн менежментийг сайжруулах, малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгаа зэрэг төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна.

1.2.4.3. Сүхбаатар аймгийн хэмжээнд 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүдийн хувьд дээр дурдсан чиг үүргийн хүрээнд байна. Өөрөөр хэлбэл ОНХС-ийн журамд заасан чиг үүрэгт хамааралгүй төсөл арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлээгүй байна.

1.2.4.4. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл арга хэмжээнүүдийг Орон нутгийн хөгжлийн сангийн журамд заасан чиг үүргээр ангилж, дараах хүснэгтэд харуулав.

(Мянган төгрөг)

№	Журамд заасан чиг үүргийн ангилал /Аймаг, сум/	Төсөл арга хэмжээний	
		Тоо	Батлагдсан төсөвт өртөг
1	Ажлын байр бий болгох	2	27,000.0
2	Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулах	34	5,514,482.4
3	Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх	17	333,800.5
4	Дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ	70	26,182,760.4

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө

5	Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, Инновац, шинжлэн ухаан, цахим технологи	95	9,802,659.0
6	Малын татварын орлогоор - Байгаль орчныг хамгаалах;	4	57,000.0
7	Малын татварын орлогоор - Бэлчээрийн менежментийг сайжруулах	11	390,500.0
8	Малын татварын орлогоор - Гэмт халдлага, гамшгаас хамгаалах;	1	17,000.0
9	Малын татварын орлогоор - Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа.	14	139,930.4
10	Малын татварын орлогоор - Малын тэжээлийн ургамал тариалах;	2	20,000.0
11	Малын татварын орлогоор - Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;	16	377,000.0
12	Малын татварын орлогоор - Малын чанарыг сайжруулах;	8	96,000.0
13	Малын татварын орлогоор - Тэжээлийн нөөц бүрдүүлэх;	16	448,000.0
14	Малын татварын орлогоор - Хортон мэрэгчидтэй тэмцэх/байгаль орчин, хүн, мал, амьтанд халгүй дэвшилтэт арга, технологи ашиглах/;	7	97,057.6
15	Малын татварын орлогоор - Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх;	2	9,000.0
16	Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах	106	13,114,116.9
17	Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулах	19	3,367,435.4
Нийт дүн		424	59,993,742.5

1.2.4.4. Нийт 424 төсөл арга хэмжээ батлагдсанаас 25 хувь нь орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах чиглэлээр, 22.4 хувь нь иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, Инновац, шинжлэн ухаан, цахим технологийн чиглэлээр, 16.5 хувь нь дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээний чиглэлээр, 8.0 хувь нь аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулах чиглэлээр, 28.1 хувь нь бусад чиглэлээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ байна.

1.2.4.5. “Өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт”-ын чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна. Харин “Ажлын байр бий болгох” чиглэлээр 27.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээ төлөвлөсөн байна. Тодруулбал Баруун-Урт сумын ОНХС-аар 5.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Агро парк” төсөл арга хэмжээ хэрэгжиж, төмс хүнсний ногоо тариалах 1 га талбайг 8 иргэнд ашиглуулж, амьжиргааг дэмжжээ. Наран сумын ОНХС-аар 22.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ахуй үйлчилгээний засвар” төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

БҮЛЭГ Б. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН 4 АРГА ХЭМЖЭЭ ТУТМЫН 1 НЬ ОГТ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

2.1. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжийг баримтлаагүй зөрчлүүд гарсаар байна.

2.1.1. Магадлалын дүгнэлтгүй зураг төслөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулах, батлагдсан төсөвт өртгөөс илүү дүнгээр гэрээ байгуулах зөрчлүүд давтагдаж байна.

2.1.1.1. Сүхбаатар аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд 12,780.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 82 төсөл арга хэмжээнд тендерийн зарласнаас оролцогч

компаниуд шаардлага хангаагүй болон нэг оролцогч үнийн санал ирүүлээгүй зэрэг шалтгаанаар 892.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 тендерт гүйцэтгэгч тодроогүй байна.

2.1.1.2. “Шинэ суурьшлын бүс байгуулах” 3,600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний барилгын ажлыг газрын зөвшөөрөлгүй, магадлалаар баталгаажаагүй зураг төсвөөр худалдан авах ажиллагааг зарлаж, гүйцэтгэж тодруулж, ажлыг эхлүүлсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 зүйлийн 3 дахь заалт “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно:”, 13 зүйлийн 3.3 дахь заалт “техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”, Барилгын тухай хуулийн 25 зүйлийн 4 дэх заалт “Энэ хуулийн 25.2, 25.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгээгүй бол барилгын ажлын зөвшөөрөл олгохыг хориглоно”-уудыг зөрчсөн байна. Зөрчлийг арилгуулах албан шаардлагыг санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсний дагуу аймгийн Засаг даргын 2024 оны 5-р сарын 27-ны 02/666 тоот албан бичгээр тус төсөл, арга хэмжээг газрын асуудал шийдэгдэж батлагдах хүртэл түр зогсоосон байна.

2.1.1.3. Эрдэнэцагаан сумын ИТХ-ын тогтоолд “Цэцэрлэгт хүрээлэн барих” төсөл арга хэмжээний төсөвт өртгийг 150 сая төгрөгөөр баталсан боловч тендерийг 525.0 сая төгрөгөөр зарлаж, шалгарсан гүйцэтгэгчтэй 514.9 сая төгрөгөөр гэрээ байгуулжээ. Тус тендерийн үргэлжлэх хугацаанд төсөвт тодотгол хийж, төсөвт өртгийг 465.8 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн боловч гэрээний дүн, тендер зарласан төсөвт өртгөөс бага байна. Мөн магадлалын дүгнэлт 2023.12.26-нд гарч 510 сая төгрөгөөр төсөвт өртгийг баталсан байна. Өөрөөр хэлбэл магадлал хийлгээгүй үр дагавар нь тендерийг төсөвт өртгөөс өндөр дүнгээр зарлах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.1.1.4. Мөнххаан сумын ИТХ “Төв талбайн ажил”-ын магадлалын дүгнэлтэд үндэслэлгүйгээр, тайлант онд санхүүжих 200.0 сая төгрөгөөр төсөвт өртгийг баталсны улмаас батлагдсан төсөвт өртгөөс давсан дүнгээр буюу 321.0 сая төгрөгөөр тендер зарласан зөрчил гарсан байна. Мөн тендерийн үнэлгээний хороо эрчим хүчний ажил хийх тусгай зөвшөөрөлгүй “Хүрэл соёмбо” ХХК-ийг 75.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан байна. Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөлгүй компани шалгаруулж гүйцэтгүүлснээр шаардлага хангахгүй, чанаргүй ажил хийгдэх эрсдэлтэй байна.

2.1.1.5. Дарьганга сумын ОНХС-ийн хөрөнгөөр “Сумын төвийн хашлага хамгаалалт” төсөл арга хэмжээний тендерийг 66.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зарлаж, Тогоон төмөр констракшн ХХК шалгарч 63.3 сая төгрөгөөр гэрээ байгуулсан боловч тендерийн хэмнэлт 3.4 сая төгрөгөөр нэмэлт ажил гүйцэтгэх байгуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.3 дахь /хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх/ заалтыг зөрчсөн байна. Тус зөрчилд санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж хүргүүлсэн.

2.1.2. Банкны баталгаагүйгээр урьдчилгаа олгох, бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгох зөрчил гарсаар байна.

2.1.2.1. Гэрээ байгуулсан төсөл арга хэмжээнүүдийг авч үзэхэд 38,980.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 323 төсөл арга хэмжээн тайлант онд хэрэгжсэн байна. Үүнээс 21,692.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 280 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 17,287.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 43 төсөл арга хэмжээний хэрэгжилт дутуу байна. Дутуу хэрэгжсэн төсөл арга хэмжээний санхүүжилтэд 8,705.9 сая төгрөг олгосон байна.

2.1.2.2. Дарьганга, Сүхбаатар, Түвшинширээ, Түмэнцогт, Уулбаян, Халзан, Эрдэнэцагаан сумд 21 төсөл арга хэмжээний 476.7 сая төгрөгийн санхүүжилтийг банкны баталгаагүйгээр урьдчилж олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.дахь заалтыг зөрчсөн.

2.1.2.3. Тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээний өртгийг зах зээлийн үнээс өндрөөр төсөвт тусган, баталж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байж болзошгүй дараах зөрчил байна. “Зөөврийн наадмын талбай - Дарьганга сум” төсөл арга хэмжээний төсөвт өртгийг 400.0 сая төгрөгөөр төсөвт тусган баталсан байна. Иймд зөөврийн наадмын талбайн худалдан авалттай холбоотой асуудлыг нарийвчлан шалгах ажиллагаа үргэлжлүүлэн хийгдэж байна. Тодруулбал хөрөнгийн үнэлгээний компанитай гэрээ байгуулж, 2023 оны 7 дугаар сарын байдлаарх үнэлгээг хийлгэсэн. Мөн хээрийн үзвэрийн асрыг техникийн тодорхойлолт болон нийлүүлэгч компанийн ирүүлсэн үнийн саналаас 2 ширхэг нийлүүлэгдэхээр байхад 1 ширхэг нийлүүлэгдсэн /76,950.0 мянган төгрөг/ байна. Хоймрын асарт 30 сандал 6 ширээ, 18 жижиг асарт 10 сандал 2 ширээ дутуу, нийт 210 сандал, 42 ширээ нийлүүлэгдсэн /210*69.0 мянган төгрөг=14,490.0 мянган төгрөг, 42*85.5 мянган төгрөг =3,591.0 мянган төгрөг, нийт 18,081.0 мянган төгрөг/ байна. Нийт 95,031.0 мянган төгрөгийн асар, ширээ, сандал дутуу нийлүүлэгдсэн байна. Иймд тус зөрчилтэй холбоотой асуудлаар аудитад хамрагдагч байгууллагаас тодруулга авч, эцэслэхээр хүлээгдэж байна.

2.1.2.4. Түвшинширээ сумын хүүхдийн тоглоомын талбайг 85.0 сая төгрөгийн тендерт Жоди прожект ХХК нь шалгарч, гүйцэтгэсэн боловч 1 ширхэг сандал 350.0 мянган төгрөг, 2 ширхэг хогийн сав 800.0 мянган төгрөг, 1 ширхэг хүүхдийн тоглоом 8,000.0 мянган төгрөг, явган замын бордуур 5,050.0 мянган төгрөг нийт 14,200.0 мянган төгрөгийн ажил дутуу хийсэн байхад санхүүжилтийг бүрэн олгосон тул дутуу хийгдсэн ажлыг хийлгэх албан шаардлага өглөө.

2.1.2.5. Сумдын ОНХС-ийн тендерийн баримт бичигт чанарын баталгаа гаргуулах талаар тодорхой тусгаж өгдөггүй, үүний улмаас чанарын баталгааг банкны баталгаагаар гаргуулаагүй, эсхүл чанарын баталгаат хугацааны барьцааг санхүүжилтээс суутган авч үлдэхгүй байна. Энэ нь чанарын баталгаат хугацаанд ямар нэгэн эвдрэл, гэмтэл, доголдол үүсэхэд тухайн гүйцэтгэгч компани засварлаагүй тохиолдолд захиалагчийн зүгээс засварлах хөрөнгийн эх үүсвэргүй болох сөрөг үр дагавартай байна.

2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 4 арга хэмжээ тутмын 1 нь огт хэрэгжээгүй байна.

2.2.1. Магадлалын дүгнэлтгүй төсөл арга хэмжээг баталж байгаа нь тухайн төсөл арга хэмжээ хэрэгжихгүй байх, хугацаа алдахад нөлөөлж байна.

2.2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр төлөвлөсөн 4 төсөл арга хэмжээ тутмын 1 нь огт хэрэгжээгүй байна. Өөрөөр хэлбэл 59,993.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 424 төсөл арга хэмжээ батлагдсанаас 14,325.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 101 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Хэрэгжээгүй шалтгаан нь магадлалын дүгнэлтгүй төсөл, арга хэмжээ төлөвлөсөн, төсөв батлагдсанаас хойш зураг төсөлд магадлалын дүгнэлт гаргуулсны улмаас батлагдсан төсөвт өртөг багадаа худалдан авах ажиллагаа зохион байгуулах боломжгүй болох, тендерт компани оролцохгүй байх, малын тоо толгойн татварын орлого бүрэн төвлөрөхгүй байх зэрэг шалтгаанаар хэрэгжээгүй байна.

2.2.1.2. Тайланд онд бүрэн хэрэгжсэн 21,692.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 280 төсөл арга хэмжээнээс 222.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 6 төсөл арга хэмжээ ашиглагч байгууллага дунд зэргийн чанартай гэж үнэлснээс зорилтот түвшинд хүрээгүй байна.

2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнээс 14,325.2 төгрөгийн төсөвт өртөгтэй 101 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

2.2.2.1. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр бүрэн хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийг нийт батлагдсан төсөл арга хэмжээтэй харьцуулж үзэхэд Баруун-Урт, Баяндэлгэр, Түвшинширээ, Уулбаян сумдын төсөл арга хэмжээ 70-аас дээш хувь нь бүрэн хэрэгжсэн байна. Мөнххаан, Онгон сумдын хувьд батлагдсан төсөл арга хэмжээний 46.7-50 хувь нь бүрэн хэрэгжсэн байна.

Аймаг, сумын нэр	Бүрэн хэрэгжсэн		Дутуу хэрэгжсэн		Огт хэрэгжээгүй		Нийт төсөл, арга хэмжээ		Хувь
	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	
Аймаг	44	16,130,587	18	12,948,503	13	9,170,495	75	38,249,585	58.7
Асгат	18	294,236	3	197,000	5	60,500	26	551,736	69.2
Баруун-Урт	30	2,683,760	4	311,360	7	147,000	41	3,142,120	73.2
Баяндэлгэр	25	1,185,006	0	0	8	139,000	33	1,324,006	75.8
Дарьганга	19	663,489	1	100,000	11	285,042	31	1,048,531	61.3
Мөнххаан	13	859,343	3	329,000	10	121,800	26	1,310,143	50.0
Наран	10	126,744	0	0	8	814,418	18	941,162	55.6
Онгон	7	613,084	3	353,757	5	310,838	15	1,277,679	46.7
Сүхбаатар	17	2,886,667	3	2,028,057	1	20,000	21	4,934,724	81.0
Түвшинширээ	21	595,172	0	0	8	313,365	29	908,537	72.4
Түмэнцогт	16	299,401	0	0	2	255,898	18	555,299	88.9
Уулбаян	17	446,067	4	547,213	2	50,000	23	1,043,280	73.9
Халзан	8	215,000	1	301,523	6	154,868	15	671,390	53.3

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө

Эрдэнэцагаан	35	932,552	3	621,000	15	2,482,000	53	4,035,552	66.0
Нийт	280	27,931,106	43	17,737,413	101	14,325,223	424	59,993,743	66.0

2.2.2.2. Бодлогын баримт бичиг болон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний орон нутгийн хөгжилд үзүүлж буй хувь нэмэр, үр нөлөөг хэмжихэд хэрэгжилтийг хувийг харгалзаж үздэг. Сүхбаатар аймгийн ОНХС-аар батлагдсан төсөл арга хэмжээнд бүрэн хэрэгжсэн төсөл арга хэмжээний эзлэх хувь дунджаар 66.0 хувьтай байна.

2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

2.3.1. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.

2.3.1.1. Аймаг, сумын ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалтыг авч үзэхэд бүрэн хэрэгжсэн төсөл арга хэмжээний урсгал зардлаас бусад хөрөнгийн шинж чанартай 178 төсөл арга хэмжээний 20,098.4 сая төгрөгийн үнийн дүнтэй барилга, тоног төхөөрөмж, бараа материал зэрэг хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.

2.3.2. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зохистой байна.

2.3.2.1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр бий хөрөнгийг холбогдох шийдвэрийг үндэслэн данс бүртгэлд тусгаж байна. Улмаар сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгө нь ашиглагч байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн хяналтад орж, хадгалалт, хамгаалалтыг тухайн байгууллагууд хариуцаж байна.

БҮЛЭГ В. ШАТ ШАТНЫ ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХИЙН ТУЛД ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛЖ, СУРГАЛТ ХИЙХ ШААРДЛАГА ҮҮССЭН БАЙНА.

3.1. Магадлалын дүгнэлтгүй төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж байгаа нь шат шатны хяналтыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

3.1.1. Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, дотоод аудит нь ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд хяналтыг хэрэгжүүлсэн байна.

3.1.1.1. Аймаг, сумын ИТХ сумдын ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан боловч харилцан адилгүй арга зүйгээр хяналтыг хэрэгжүүлсэн байна. Аймгийн ИТХ-аас аймаг, сумын ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт хийж дараах чиглэлээр зөвлөмж, чиглэл хүргүүлж ажилласан байна. Үүнд:

- Иргэд, олон нийтэд нээлттэй санал асуулга, хэлэлцүүлгийг журамд заасны дагуу үе шаттай зохион байгуулах. Хэлэлцүүлгийн тэмдэглэлийг оролцсон иргэдийн гарын үсгээр баталгаажуулж ажиллах
- ОНХС-ийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагыг ИТХ-аар жил бүр хэлэлцүүлж байх;

3.1.1.2. Мөн АИТХ-ын хийсэн хяналтын хүрээнд иргэдээс авсан санал асуулгаар 38.2 хувь нь ундны усыг сайжруулж цэвэршүүлэх, 19.1 хувь нь эрүүл мэндийн үйлчилгээ чанарыг сайжруулах ажил, 9.7 хувь нь нэгдсэн халаалттай болох, 33 хувь нь бусад ажлын талаар санал өгсөн байна. Үүнтэй холбоотой иргэдийн хамгийн их ирүүлж буй дээрх саналуудад чиглэсэн төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхийг ОНХС хариуцсан албан хаагчдад зөвлөмж болгосон байна.

3.1.1.3. Санхүүгийн хяналт, аудитын алба аймгийн ОНХС болон сумдын ОНХС-ийн үйл ажиллагааг шалгах бие даасан төлөвлөгөөгөөр 2023 онд хяналт хэрэгжүүлж ажилласан байна. Дараах чиглэлээр зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнд:

- Малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлэхэд анхаарлаа хандуулж, багийн засаг дарга болон татварын байцаагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг хангуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах. Малын тоо толгойн албан татварын тухай хууль болон орон нутгийн хөгжлийн сангийн журмын талаар малчдад сургалт, мэдээлэл олгож хэвших.
- Багийн засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулах, иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх тал дээр тусгайлсан сургалт мэдээлэл өгч хэвших, цахим технологи ашиглаж санал авах боломжийг судалж хэрэгжүүлэх.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдийн саналгүй, эрэмбэлсэн жагсаалтад ороогүй, сумын үндсэн чиглэлд тусгагдаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж батлахгүй байх.
- Удирдлага мэдээллийн систем /www.onhs.gov.mn/-д холбогдох ажилтан албан хаагчид нь мэдээллээ цаг тухай бүр хуулийн хугацаанд оруулж хэвших.
- Цаашид журмын дагуу ОНХС-ын үйл ажиллагааг мөрдөж ажиллах, иргэдийн хувийн өмчлөлттэй холбогдолтойгоор төсөл арга хэмжээг төлөвлөн, санхүүжүүлэхгүй байх.

3.1.2. Магадлалын дүгнэлтгүй төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж байгаа нь барилгын техник хяналт хэрэгжихгүй байхад шууд нөлөөлж байна.

3.1.2.1. Барилгын техник хяналт хэрэгжсэн байдлыг авч үзэхэд Баруун-Урт, Сүхбаатар, Уулбаян, Эрдэнэцагаан сумд 2023 онд хяналт хийлгэсэн, Халзан, Онгон, Асгат, Түмэнцогт сумд гэрээ байгуулсан боловч төсөл арга хэмжээнүүд магадлалын дүгнэлтгүй болон ажил эхлээгүй шалтгааны улмаас хяналт хийгдээгүй бөгөөд бусад сумд гэрээ огт байгуулаагүй байна. Харин 2024 онд бүх сумд “Сүхбаатар хот байгуулалт, орон сууц, барилга захиалагч” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулж, барилгын техник хяналтыг тус байгууллагаар хийлгэж байна.

3.1.2.2. Барилгын техник хяналт зарим төсөл арга хэмжээний хувьд хэрэгжихгүй байгаа шалтгаан нь тухайн төсөл арга хэмжээний зураг төсвийг магадлалаар баталгаажуулаагүйтэй холбоотой байна. Магадлалаар баталгаажаагүйн улмаас барилгын ажил эхлэх зөвшөөрөл олгох боломжгүй, барилгын ажлын зөвшөөрөлгүйн улмаас барилгын техник хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

3.1.2.3. Тухайлбал аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн наадмын талбай барих төсөл арга хэмжээний хувьд гэрээ байгуулж, ажил эхэлснээс хойш зураг төслийн магадлалын дүгнэлт гарсантай холбоотойгоор тус барилгын ажил захиалагчийн техник хяналтгүйгээр хэрэгжсэн байна.

3.1.3. Өмнөх аудитаар хүргүүлсэн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

3.1.3.1. Өмнөх оны аудитаар хүргүүлсэн зөвлөмж, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг дараах хүснэгтээр харууллаа. Үүнд:

Хэнд өгсөн	Зөвлөмж	Зөвлөмжийн хэрэгжилт
Аймаг, сумын ИТХ-ын дарга нарт	1. Орон нутгийн төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэхдээ иргэд, олон нийтийн саналаар дэмжигдээгүй, орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг батлахгүй байх.	АИТХ-аас байгуулсан ажлын хэсэг сумдын ИТХ-ын 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, ОНХС-ийн журмын хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг сумын ИТХ-ын дарга нарт хүргүүлсэн байна. Иргэд, олон нийтийн саналаар дэмжигдээгүй төсөл арга хэмжээг батлах зөрчил давтан гарсаар байна.
Аймаг, сумын Засаг дарга нарт	1. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу малын тоо толгойн татвар, хандив, сангаас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон өвс тэжээл, малжуулах төслийн авлагыг бодитой тооцож, нөөц бололцоогоо бүрэн дайчлан орлогыг бүрдүүлэх.	Сумдын ЗДТГ малын тоо толгойн орлогыг төвлөрүүлэх талаар тодорхой ажлуудыг зохион байгуулж ажилласан байна. Гэсэн хэдий боловч 2 жил дараалан тохиолдсон байгаль цаг уурын хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан 2023 оны малын тоо толгойн албан татварын орлогын төвлөрүүлэлт 17.5 хувьтай байна.
	2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт болон хяналт шалгалтын тайланг иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлж, Удирдлагын мэдээллийн системийн ашиглалтыг сайжруулан иргэдийг мэдээллээр ханган, тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллан, журмын хэрэгжилтэд хяналт тавьж, албан тушаалтнуудад хариуцлага тооцож ажиллах.	Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний мэдээллийг УМС-д мэдээлэхээс гадна вэб сайт, орон нутгийн “Сүхбаатарын өнгө” сонин болон олон нийтийн цахим сүлжээгээр ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг нийтлүүлж, иргэдийг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулж, Багийн иргэдийн Нийтийн хурал дээр мэдээлэл, танилцуулга хийж, иргэдийн санал хүсэлтийг сонссон байна. АЗДТГ-т 2024 онд ОНХС хариуцсан мэргэжилтэнтэй болж, УМС-ийн 2023 оны мэдээллийг бүрэн байршуулах ажлыг зохион байгуулж ажилласан байна.
	3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,	“Урьдчилгаа төлбөрийн баталгаа” ирүүлээгүй тохиолдолд урьдчилгаа санхүүжилт олгох, барилгын ажил гүйцэтгэх төсөл арга хэмжээний хувьд магадлалаар баталгаажсан зураг төсөлгүй тохиолдолд

ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах.	төсөвт тусгаж, худалдан авах ажиллагаа зохион байгуулах зөрчлүүд бүрэн арилахгүй байна.
4. Захиалагчийн хяналтыг зохих журмын дагуу хэрэгжүүлж, сангийн хөрөнгийн үр нөлөө, үр дүнг сайжруулах.	АИТХ-ын 2023 оны 03 сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор аймаг, сумын ОНХС, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилгын ажлын захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Сүхбаатар хот байгуулалт, орон сууц, барилга захиалагч” ОНӨААТҮГ байгуулагдсан байна. Тус байгууллага нь аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжүүлж эхэлсэн барилгын ажил гүйцэтгэх төсөл, арга хэмжээнүүдийн захиалагчийн хяналт хийх гэрээг сумын Засаг дарга нартай байгуулан, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж эхэлсэн байна.

3.2. Удирдлагын мэдээллийн систем болон шилэн дансанд сумдын байршуулж буй ОНХС-ийн мэдээлэлд АЗДТГ-аас хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг холбогдох журам, зааврын дагуу хугацаанд нь тайлагнасан байна.

3.2.1.1. Сумдын ЗДТГ-аас ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж, аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн байна.

3.2.1.2. Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс аймаг, сумын ОНХС-ийн 2023 оны хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.9-д заасны дагуу Сангийн яаманд хүргүүлсэн байна.

3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээний 97.8 хувийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

3.2.2.1. Аймаг, сумын ОНХС-ийн 2023 онд бүрэн хэрэгжсэн 21,109.9 сая төгрөгийн 280 төсөл арга хэмжээнээс 6 төсөл арга хэмжээ данс бүртгэлд тусгаагүй байна. Төсөл арга хэмжээний бүртгэлийг төсөвт байгууллагын үндсэн хөрөнгө, нийтийн эзэмшлийн үндсэн хөрөнгө, бараа материал, урсгал зардал, бүртгэлд тусгаагүй гэсэн ангиллаар дараах хүснэгтэд харууллаа.

№	Үзүүлэлт	Бүрэн хэрэгжсэн нийт төсөл арга хэмжээ	Төсөвт байгууллагын -Үндсэн хөрөнгөөр	Нийтийн эзэмшлийн -Үндсэн хөрөнгөөр	Бараа материал	Урсгал зардлаар хүлээн зөвшөөрсөн	Бүртгэлд тусгаагүй
1	Төсөл арга хэмжээ	280	111	22	42	99	6
2	Мөнгөн дүн	21,109.9	9,999.95	2,221.64	2,928.98	1,957.40	4,001.92

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн Өрхийн эмнэлгийн барилга /Баруун-Урт сум/, Аймгийн төв цэнгэлдэх хүрээлэн, Баруун-Урт хотын иргэдийг орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд баригдах орон сууцуудын гадна цахилгаан хангамжийн тоног төхөөрөмж худалдан авах суурилуулах, “Аймгийн засаг даргын тамгын газрын барилгын их засвар шинэчлэлийн ажил”, Баяндэлгэр сумын ОНХС-аар хийгдсэн “Бэлчээр усан хангамж сайжруулах энгийн уурхай худаг гаргах”, Эрдэнэцагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн “Музейн үзмэрт баяжилт хийх” төсөл арга хэмжээнүүдийг данс бүртгэлд тусгаагүй байна. Эдгээр төсөл арга хэмжээнүүдийг бүртгэл тайланд тусгах ажил 2024 онд хийгдэж байна.

3.2.3. Удирдлагын мэдээллийн системд байршуулж буй төсөвт өртөг, гэрээний үнийн мэдээлэлд АЗДТГ-ын ОНХС хариуцсан албан хаагч хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

3.2.3.1. Орон нутгийн хөгжлийн сангийн Удирдлагын мэдээллийн системд мэдээлэл байршуулалтыг авч үзэхэд аймаг, сумын ОНХС-ийн зарим төсөл арга хэмжээний залруулсан гүйлгээнүүдийн зарцуулалт давхардаж мэдээлэгдсэн алдааг эс тооцвол олгосон санхүүжилтийн мэдээллийг төрийн сангийн системээс татуулж, бүрэн гүйцэд мэдээлсэн байна.

3.2.3.2. Сумдын ОНХС-ийн хувьд Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлагын мэдээллийн системд хэрэгжээгүй төсөл арга хэмжээний шалтгаан тайлбарыг тодорхой, дэлгэрэнгүй мэдээлээгүй, зарим төсөл арга хэмжээний төсөвт өртөг, гэрээний дүнг зөрүүтэй мэдээлсэн байна. Иймд аймгийн ЗДТГ-ын ОНХС хариуцсан албан хаагч шилэн дансны нэгдсэн цахим хуудаст орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтын мэдээлэл байршуулалтад сар бүр хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

3.2.4. Шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээлж буй орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлд АЗДТГ-ын ОНХС хариуцсан албан хаагч хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

3.2.4.1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг сар бүр өссөн дүнгээр мэдээлэхгүй байх, мөн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл талбарт төсөл арга хэмжээний гэрээний дүн, санхүүжилт (өссөн дүнгээр), гүйцэтгэлийн хувь, гүйцэтгэгчийн регистр, гүйцэтгэгчийн нэр, тендер шалгаруулалтын журам зэргийг бүрэн мэдээлээгүй зөрчил сумдын ОНХС-д нийтлэг байна.

3.2.4.2. Харин аймгийн ОНХС-ийн хувьд орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээнд гүйцэтгэгчийн регистр, тендер шалгаруулалтын журам зэрэг мэдээллийг бүрэн оруулаагүй байна.

3.2.4.3. Аймгийн ЗДТГ-ын ОНХС хариуцсан албан хаагч шилэн дансны нэгдсэн цахим хуудаст орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтын мэдээлэл байршуулалтад сар бүр хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Холбогдох байгууллагын санал:



СҮХБААТАР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70518585

2024.07.09 № 05/875
танай _____-ны № _____-г

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх тухай

Дарьганга сумын зөөврийн наадмын талбайн хээрийн үзвэрийн асар нь 2 ширхэг бөгөөд нэгтгэн нэг том болгож нийлүүлсэн болно. Мөн наадмын талбайн хоймрын болон жижиг асрын урд хэсэгт 30-40 хүний сандал ширээ, 10-15 хүний сандал ширээг нэмэлтээр зөөж авч ирж тавих боломжтой байхаар асрын урд хэсэгт зай талбай гаргаж өгөхийг тодорхойлсон. Өөрөөр хэлбэл хоймрын асарт 170 хүн, жижиг асарт 40-45 хүн багтахаар хүчин чадлыг зааж өгсөн болно.

Иймд техникийн тодорхойлолтод 670 ширхэг түшлэгтэй сандал хийх, харин ширээ нийлүүлэх гэсэн заалт байхгүй.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Х.ЭНХЦЭЦЭГ



Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын ХБТХОХ-ээс ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

Тайлбар 1	2.1.2.3-тай холбоотой саналд өгөх тайлбар: Дарьганга сумын зөөврийн наадмын талбайтай холбоотой асуудлыг нарийвчлан шалгах ажиллагаа хийгдэнэ.
-----------	---

Дүгнэлт:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт дахь 424 төсөл арга хэмжээнээс 2 төсөл арга хэмжээ нь ажлын байр бий болгоход чиглэсэн байна.
3. Иргэдийн саналгүй, магадлалын дүгнэлтгүй, мэргэжлийн байгууллагаас хийсэн зах зээлийн үнийн судалгаагүй төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсээр байна.
4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлт бодиттой хийгдээгүйн улмаас төлөвлөсөн 4 арга хэмжээ тутмын 1 нь буюу 14.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 101 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.
5. Дарьганга, Сүхбаатар, Түвшинширээ, Түмэнцогт, Уулбаян, Халзан, Эрдэнэцагаан сумд 21 төсөл арга хэмжээний 476.7 сая төгрөгийн санхүүжилтийг банкны баталгаагүйгээр урьдчилж олгожээ.
6. Сумдын ОНХС-ийн хувьд чанарын баталгаат хугацааны барьцааг төсөл арга хэмжээний санхүүжилтээс авч үлдэхгүй байгаа нь баталгаат хугацаанд гарсан эвдрэл, гэмтлийг засварлах хөрөнгийн эх үүсвэргүй болох сөрөг үр дагавартай байна.
7. Магадлалын дүгнэлтгүй төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж байгаа нь барилгын техник хяналтгүйгээр хэрэгжих, төсөл арга хэмжээний чанарт сөргөөр нөлөөлж, иргэдийн хүртэх үр өгөөжийг бууруулж байна.
8. Шат шатны хяналтын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд төрийн аудитын байгууллагын зүгээс нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран гарын авлага боловсруулж, сургалт хийх шаардлага үүссэн байна.
9. Удирдлагын мэдээллийн систем болон шилэн дансанд сумдын байршуулж буй ОНХС-ийн мэдээлэлд АЗДТГ-аас хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Зөвлөмж:

Аудитаар өгсөн дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

АЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэст:

1. Өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт болон ажлын байр бий болгох чиглэлээр төсөл арга хэмжээнд ОНХС-гийн хөрөнгийн 10-аас доошгүй хувийг төлөвлөж, хэрэгжүүлэн ажиллах
2. Тоног төхөөрөмжийн төсөл арга хэмжээний хувьд мэргэжлийн байгууллагаар зах зээлийн үнийн судалгаа хийлгэж, тухайн байгууллагын дүгнэлт, тайланд үндэслэсэн төсөвт өртгөөр орон нутгийн төсөвт төлөвлөх
3. Зам, барилга, эрчим хүчний ажлын зураг төслийн магадлалын дүгнэлт гарсан тохиолдолд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад тусгаж байх.
4. Гэрээ байгуулсан төсөл арга хэмжээнүүдийг хугацаанд нь гүйцэтгүүлэхийн тулд хууль, эрх зүйн хүрээнд шат дараалсан арга хэмжээг шуурхай авч, анхны гэрээнд заасан хугацаанд бүрэн хэрэгждэг жишгийг аймгийн хэмжээнд тогтоох.
5. Удирдлагын мэдээллийн систем болон шилэн дансанд сумдын байршуулж буй ОНХС-ийн мэдээлэлд АЗДТГ-аас сар бүр тогтмол хяналт тавих, өмнөх сарын мэдээллийг бүрэн, үнэн зөв байршуулаагүй тохиолдолд дараагийн сарын санхүүжилтийг олгохгүй байх хөшүүргийг журамд заасны дагуу хэрэглэх

Сумдын Засаг дарга нарт:

1. Өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт болон ажлын байр бий болгох чиглэлээр төсөл арга хэмжээнд ОНХС-гийн хөрөнгийн 10-аас доошгүй хувийг төлөвлөж, хэрэгжүүлэн ажиллах.
2. Тоног төхөөрөмжийн төсөл арга хэмжээний хувьд мэргэжлийн байгууллагаар зах зээлийн үнийн судалгаа хийлгэж, тухайн байгууллагын дүгнэлт, тайланд үндэслэсэн төсөвт өртгөөр орон нутгийн төсөвт төлөвлөх.
3. Зам, барилга, эрчим хүчний ажлын зураг төслийн магадлалын дүгнэлт гарсан тохиолдолд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад тусгаж байх.
4. Чанарын баталгаат хугацаанд гарсан эвдрэл, гэмтлийг засварлах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор тендерийн баримт бичигт чанарын баталгаа гаргуулах талаар тусгаж, улмаар сүүлийн санхүүжилтээс чанарын баталгаат хугацааны барьцааг суутган авч үлдэж байх.
5. Банкны баталгаагүйгээр урьдчилгаа санхүүжилт олгохгүй байх, төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож хэвших.

САНАЛ:

Төрийн аудитын байгууллагаас нутгийн захиргааны дараах байгууллагуудтай дараах чиглэлээр хамтран ажиллах санал гаргаж байна. Үүнд:

Сүхбаатар аймгийн ИТХ-д:

1. Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгч нарт ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлттэй холбоотой асуудлаар хамтарсан сургалт зохион байгуулах саналтай байна.

Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, СТСХ болон Сүхбаатар хот байгуулалт, орон сууц, барилга захиалагч ОНӨААТҮГ-т:

1. ОНХС-ийн төсөл арга хэмжээний төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, гүйцэтгэл, ашиглалтад хүлээн авах үе шатуудад мөрдөх хууль, эрх зүйн актуудын холбогдох заалтуудыг эмхэтгэсэн гарын авлага хамтран боловсруулах саналтай байна.
2. Сумдын Засаг дарга, орлогч, санхүүгийн албаны дарга, ОНХС хариуцсан нягтлан бодогч нарт Төрийн аудитын байгууллагатай хамтарсан сургалт зохион байгуулах саналтай байна.

Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, ХШҮДАХэлтэс:

1. Сумдын Засаг дарга нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Төсөвлөлтийн шаардлага хангасан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөх” гэсэн гүйцэтгэлийн арга хэмжээг нэмж тусгуулахтай холбоотой шалгуур үзүүлэлт, суурь ба хүрэх түвшнийг хамтран боловсруулах саналтай байна.

---o0o---